



НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 1/01

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1548 дугаар захирамж, “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Захирамжийн хавсралтыг шинэчлэн батлах тухай” Нийслэлийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/1548 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтын 30 дугаарт заасан ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журам, шийдвэрийг мөрдөн ажиллаж, үр дүнг тайлагнахыг Үнэлгээний хорооны дарга (Б.Лхагважав)-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий инженер (Т.Оргил-Эрдэнэ)-т даалгасугай.

4. Төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалттай холбоотой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлэн холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Г.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.МӨНХБАТ

2

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын
даргын 2023 оны 01 дүгээр сарын 05-ны
өдрийн 1/01 дүгээр тушаалын хавсралт



ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

ДАРГА:

Б.ЛХАГВАЖАВ

(НХОГ-ын Зураг төслийн
хэлтсийн дарга)

ГИШҮҮД:

Б.БАТМӨНХ

(Нийслэлийн Засаг даргын
Тамгын газрын Хууль, эрх зүйн
хэлтсийн Барилга, газрын
харилцааны эрх зүйн асуудал
хариуцсан мэргэжилтэн

Н.ЭНХБАЯР

(НХОГ-ын Барилга захиалагчийн
хэлтсийн Бүсийн Ахлах инженер)

Ц.БЯМБАЖАВ

(Баянгол дүүргийн 5 дугаар
хорооны иргэн)

НАРИЙН БИЧГИЙН

ДАРГА:

Г.БАТ-ЭРДЭНЭ

(НХОГ-ын Ус хангамж, ариутгах
татуургын хяналтын инженер)